



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ
ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

2020

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО⁹²

УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор тус тус баталсан. Энэхүү төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгох”-оор тусгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж заасан юм.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төсөлд зардал, ачааллыг тооцох, зардлыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго чиглэнэ.

Энэхүү судалгаагаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсэхийг урьдчилан гаргах юм. Уг төсөлд шүгэл үлээснээр иргэнд, хуулийн этгээдэд зардал, ачаалал үүсгэх, үүрэг болгосон заалт тусгаагүй, харин төрийн байгууллагад зардал, ачаалал үүсгэх зохицуулалт туссан байна. Иймд тухайн үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг аргачлалын дагуу дараах алхмаар тооцож үзлээ. Үүнд,

1. Төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг,
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийн зардлыг тооцох,
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох,
4. Нийт дүнг тооцон тэдгээрийг бууруулах боломжтой эсэхийг судлан боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон болно.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Энэ бүлэгт Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн /цаашид “төслийн” гэх/ төрийн байгууллагад үүрэг оногдуулсан зарим зохицуулалтууд нь төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох юм. Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гуравдугаар бүлэг, 16 дугаар зүйл, Дөрөвдүгээр бүлэгт заасан хэсгүүдэд төрийн байгууллагад үүсэх зардалтай шууд ба шууд бус хамаарал бүхий зохицуулалт орсон боловч төрд зайлшгүй зардал ачаалал үүсэх үүргийг бий болгосон зохицуулалтыг тодорхойлон, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог анхааран үзэж, голлон үүрэг гүйцэтгэх байгууллага, түүнд хамааралтай заалтыг авч үзлээ.

⁹² Энэхүү судалгааг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

Хүснэгт 1. Төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт

Хуулийн төслийн зүйл, заалт	Зохицуулалт	Хэрэгжүүлэх байгууллага
3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.6 дахь заалт, Гуравдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэг	Шүгэл үлээгчийг хамгаалах	Авлигатай тэмцэх газар
6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалт, Дөрөвдүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 20.10 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 22 дугаар зүйл	Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох	Авлигатай тэмцэх газар

Дээрх хүснэгтэд дурдсан “шүгэл үлээгчийг хамгаалах” болон “мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох”-д шаардлагатай зардалд хамаарагдах хүчин зүйлсийг тодорхойлохын зэрэгцээ улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилан тооцох болно.

Түүнчлэн хуулийн төсөлд дурдсан бүх байгууллагын зардлыг биш гүйцэтгэх үүрэгт гол ачаалал үүрэх байгууллагыг сонгон⁹³ авч зардлыг тооцох юм. Гол ачаалал үүрэх байгууллага нь төслийн 6 дугаар зүйлийн 1-д “Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараах асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана” гэж заасан байх тул Авлигатай тэмцэх газар нь (цаашид “АТГ” ээх) гол үүргийг гүйцэтгэхээр байна.

“Шүгэл үлээгчийг хамгаалах”-д үүсэх зардлыг АТГ-тай холбогдуулан авч үзэх хэдий ч аргачлалын дагуу тус байгууллагын стандарт үйл ажиллагааг нарийвчлан тооцох боломжгүй. Учир нь Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалд “...хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх”, “журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Иймд, Нийслэлийн Цагдаагийн газар /цаашид “НЦГ” гэх/-ын дэргэдэх “Түр хамгаалах байр” болон ХЭҮТ, ХТЭТ-ийн хамгаалах байранд байрлуулж, хэлтсийн зүгээс шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг⁹⁴ тул эдгээрээс төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасныг жишиг болгон “хамгаалалтын арга хэмжээ”-ний зардлыг тооцов. Хүний нөөцийн зардал, материаллаг зардлыг авч үзэхдээ холбогдох дүрэм, журамд заасан жишгийг баримталсан болно.

Нөгөө талаас нь авч үзвэл Гуравдугаар бүлгийн 16 дугаар зүйлд “Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах” тухай заасан хэдий ч 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаас бусад 16.2-16.6 дахь заалтад “болно” гэсэн нь болохгүй ч байж болох хоёрдмол утгыг агуулж буй нь 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэгт заасан аюулгүй байдлыг хамгаалахгүй, зардал үүсгэхгүй ч байж болох юм. Иймд, төслийн 16 дугаар зүйлийн “болно” гэдгийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоолд заасан аргачлалын дагуу ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар томъёолох нь зүйтэй байна.

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт “Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох” хэмээн заасан нь төрийн байгууллага, улсын төсөвт шууд утгаар зардал, ачаалал үүсгэсэн гэж үзсэний үндсэн дээр судлан үзвэл, аргачлалын 4.1.1 дэх хэсэгт зааснаар АТГ-т Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулан мөнгөн шагнал олгох тухай хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтад үүрэг хүлээлгэсэн байна. /хавсралт 2/ Мөн “мөнгөн шагнал” олгох тухай заасан нь төрийн байгууллагад зардал, ачааллыг бий

⁹³ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, ГЗ, УБ., 2016 он, 279 дэх тал.

⁹⁴ Түр хамгаалах байр <http://www.mnb.mn/i/170106/сүүлд үзсэн> 2020.02.04/

болгосон байх боловч хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан орлогод хамаарах үнийн дүнгээс 50 хүртэл хувийг тооцон “мөнгөн шагнал” олгох талаар зохицуулсан нь төрийн байгууллагын орлогод хамаарах үнийн дүнгээс бага хувийг эргүүлэн шагнал болгон олгох тул төсөвт орлого бүрдэх боломжтой гэж үзэж байна.

Гэхдээ төрийн байгууллагад орох орлогыг уг хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан “... захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан олж авсан...” гэж зааснаар хэрэгжүүлэх боломжгүй юм. Учир нь 1/ нийтийн ашиг сонирхлыг “захиргааны байгууллагад” гэж хязгаарласан, 2/ “учирсан хохирлыг” гэж өнгөрсөн цагт авч үзсэн нь хуулийн зорилгод тодорхойлсон үндсэн үзэл санааг хэрэгжүүлэхэд саад болох төдийгүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “олон нийтийн итгэл” гэснийг, хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “...хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн” гэсэн заалттай зөрчилдөж байх тул хууль хоорондын болон хуулийн төслийн зүйл заалт хоорондын уялдаа холбоог ханган, шүгэл үлээгчийг дэмжсэн хууль бус үйлдэлтэй тэмцсэнээр уг хуулийн төслийн үзэл санаа бүрэн утгаар хэрэгжих төдийгүй төрийн байгууллагад орлого бүрдэх боломжтой болох юм.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан урамшууллыг шүгэл үлээгчийн ажиллаж байгаа байгууллагаас гаргах тухай заасан нь үүссэн нөхцөл байдлаас шалгаалан тодорхой тохиолдолд төрийн байгууллагаас зардал гарахгүй байх боломжтой юм.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг авах тухай хүсэлт гаргаж болох тухай заасан хэдий ч хэн, хэзээ, хэрхэн олгох талаар уг хуулийн төсөлд тусгаагүй байх хуулийн хийдэл үүсэж болзошгүй бөгөөд зардал тооцох боломжгүй байна.

1.2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох

Хуулийн төсөлд туссан “шүгэл үлээгчийг хамгаалах” арга хэмжээг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх байгууллага болох Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ		Стандарт үйл ажиллагаа
Авлигатай тэмцэх газар	Шүгэл үлээгчийг хамгаалах /НАСТШҮХ-Х 3.1.2 буюу хамгаалалтын арга хэмжээ/	Аюулгүй байдлын хамгаалалт	гэмт хэрэг үйлдэхээр заналхийлсэн эсэхийг тогтоох
			урьдчилан сануулах
			тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар олж мэдэх
			мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна
			тодорхой үйлдлийг хязгаарлах
			тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан тухай мэдэгдэж гарын үсэг зуруулна
			хяналт тавина
			биечилсэн хамгаалалт
			харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлэхэд томилогдох хүний тоо, хугацааг тогтоох
			хамгаалалтад гарах
		мэдээллийн нууцлалыг хангах	мэдээллийн нууцлалыг хангахтай холбоотой байгууллага, албан тушаалтантай холбогдох бичиг явуулах

			нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах	нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах
			аюулгүй газарт түр байрлуулах	аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах
			нүүлгэн шилжүүлэх	нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэх
			баримт бичгийг солих	иргэний бүртгэл, болон бусад холбогдох баримт бичгийг солиход албан тушаалтанд албан бичиг явуулах
			гадаад төрхийг өөрчлөх	гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх
				үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх
				гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг авах
		Сэтгэл зүйн хамгаалалт	шүгэл үлээгчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах	шүгэл үлээгчийг хамгаалалтад авах
			шүгэл үлээгчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	сэтгэл зүйчийг томилох
			шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	сэтгэл зүйч нь шүгэл үлээгчтэй уулзах
			шаардлагатай бусад арга хэмжээ	сэтгэл зүйн таагүй нөхцөл үүсэж буйг тогтоох
			шүгэл үлээгчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	үүссэн нөхцөл байдлыг мэдээлэх
			шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	олж мэдэх
			шаардлагатай бусад арга хэмжээ	мэдээллэх
			шүгэл үлээгчийг хүлээн авсан тэмдэглэл үйлдэх	сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	шүгэл үлээгчийг хүлээн авсан тэмдэглэл үйлдэх
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	эрсдэлийн түвшинг тодорхойлох
	Хамгаалалтын арга хэмжээ	хамгаалах үйлчилгээ ⁹⁵ байрны	шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	шүгэл үлээгчийг эрсдэлийн түвшнээс шалтгаалан хамгаалах байр, бусад газарт хүргэж өгөх
			шүгэл үлээгчийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл үйлдэх	шүгэл үлээгчийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл үйлдэх
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, (эм бэлдмэлээр хангах)
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	хоол, хүнсээр хангах
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	номын сангийн үйлчилгээ үзүүлэх
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	дэмжих бүлгийн ярилцлагад оруулах
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх
			шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	нотлох бичиг баримт бүрдүүлэх

⁹⁵ ХЗДХ сайдын 2017.2.14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримжаалав.

			бичиг баримттай холбоотой үйлчилгээ ⁹⁶
			сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх
			мэдээ, мэдээллээр хангах
			сургалтад хамруулах

Дээрх АТГ-аас “хамгаалалтын арга хэмжээ” авахад гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг хууль, дүрэм журамд зааснаар тодорхойлбол, тус газрын аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн хамгаалалтыг нэгтгэн анхан шатны туслалцаа үзүүлэх “хамгаалалтын арга хэмжээ”-г явуулахтай холбоотой зардлыг тооцох нь зүйтэй юм.

ХОЁР. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

Төсөл дэх төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах ажил, үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож, хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг тогтоох юм. Хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал нэмэгдэхийг урьдчилан тооцох боломжтой.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалдаг.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлогт тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоосон зүйлгүй байна. Иймд стандартад тооцох тохиолдлын тоог адил төстэй үйлчилгээ үзүүлдэг ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах төвийн хамгаалалтад авсан иргэдийн сүүлийн 4 жилийн дундаж тоо, АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн сүүлийн 4 жилийн дундаж үзүүлэлтээр авч үзсэн.

2015-2018 оны байдлаар АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас **2,370**, үүнээс харьяаллын дагуу шилжүүлсэн **288**, хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн **796**, хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан **1241** гомдол, мэдээлэл байна.⁹⁷

Хүснэгт 3. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоо

Тохиолдол	2015 он	2016 он	2017 он	2018 он	Жилийн дундаж
Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл	440	414	658	858	593

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн дөрвөн жилийн дундаж үзүүлэлт нь 593 байна. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх /илчлэх/ нь зөвхөн авлигатай холбоотой асуудлаар хязгаарлагдахгүй хэдий ч нийтийн ашиг сонирхолтой холбоотой мэдээлсэн иргэдийн нэгдсэн мэдээлэл, тоо бүртгэл байхгүйгээс шүгэл үлээгчийн тоог бодитой гаргах боломжгүй, мөн байгууллага доторх шүгэл үлээгчийн мэдээлэл тодорхойгүй байна. Иймд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог баримжаалан хамгаалалтад авах боломжтой иргэдийн тоог гаргавал илүү ойролцоо утгаар гарч болох юм.

⁹⁶ Бүртгэлийн гэрчилгээ олгохоос эхлээд улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа авах хүртэлх үйлчилгээ багтах юм.

⁹⁷ Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018), 72 дахь тал.

Учир нь ажил үйлчилгээг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэх талаар судалж байгаа тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг нарийвчлан авч үзэж зарцуулах хугацааг тодорхойлох шаардлагатай. Төслийн Гуравдугаар бүлгийн “Шүгэл үлээгчийг хамгаалах” хэмээх үүрэгтэй төстэй үүрэг хэрэгжүүлдэг ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн өдөр тутам хийгддэг ажиллагаа, хамгаалалтад авсан иргэдийн тоог авч үзье:

Хүснэгт 4. Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоо⁹⁸

Тохиолдол	2015 он	2016 он	2017 он	2018 он	Жилийн дундаж
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад авсан иргэдийн тоо	85	42	36	65	57

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хамгаалалтад авсан иргэдийн жилийн дундаж нь 57 иргэн байх ажээ.

2.1. Зарцуулах хугацааг тодорхойлох

Тагнуулын ерөнхий газар гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа явагддаг эсэх нь тодорхойгүй, нууц байх тул 57 гэсэн тоогоор тохиолдлын тоог тооцох нь хангалтгүй төдийгүй нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн зорилгод заасныг хэрэгжүүлбэл ирээдүйд хамгаалалтад авах иргэдийн тоо, зардал ачаалал нэмэгдэх нь зайлшгүй тул хамгаалалтад авагдсан иргэдээс гадна АТГ-ын мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон авч үзэн хоёр янзаар хүний нөөцийн хэрэгцээг тодорхойллоо.

2.1.1. Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүснэгт 5. “Хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа⁹⁹

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
“Хамгаалалтын арга хэмжээ”	Шүгэл үлээгчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	57	570
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	57	855
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45 ⁹⁹	57	2736
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	57	570
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	57	570
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	57	855
	Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	57	1140
	Хоол, хүнсээр хангах	20	57	1140
	Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	57	1710
	Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	57	1710
	Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	57	2565
	Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	57	1425

⁹⁸ Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоог ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн буюу нэг байгууллагын хэмжээнд авсан.

⁹⁹ Нэг байршлаас нөгөө байршил руу ирэх, очих хугацаа, замын хөдөлгөөний нягтаршил зэргийг харгалзан дээд хугацаагаар тооцов.

Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45 ¹⁰⁰	57	2565
Мэдээ, мэдээллээр хангах	15	57	855
Сургалтад хамруулах	120	57	6840
Нийт	455	57	26,106

Дээрх хүснэгтээс үзвэл анхан шатны туслалцаа “хамгаалалтын арга хэмжээ” үзүүлэхэд жилд дунджаар 26,106 минут буюу 435 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 435 ажлыг цаг: 1600 цаг¹⁰¹ = 0.27 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон авч хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар тодорхойлж үзлээ.

2.1.2. Хохирогч иргэдийн тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүснэгт 6. “Хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа / мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
“Хамгаалалтын арга хэмжээ”	Шүгэл үлээгчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	593	5930
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	593	8895
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45	593	26685
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	593	5930
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	593	5930
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	593	8895
	Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	593	11860
	Хоол, хүнсээр хангах	20	593	11860
	Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	593	17790
	Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	593	17790
	Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	593	26685
	Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	593	14825
	Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	593	26685
	Мэдээ, мэдээллээр хангах	15	593	8895
	Сургалтад хамруулах	120	593	71160
	Нийт	455	593	269,815

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоогоор “хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардлагатай анхан шатны туслалцаа үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тооцож үзвэл жилд дунджаар 269,815 минут буюу 4,497 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 4,497 ажлын цаг: 1600 цаг = 2.8 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай болно.

¹⁰⁰ Энэ нь анхан шатны зөвлөгөө өгөх хугацаа бөгөөд сэтгэл заслын эмчилгээ 2 жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг байна.

¹⁰¹ Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын цагт хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх ажлын байрны тоо гарна.

ГУРАВ. ГАРАХ ЗАРДЛЫГ УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ

Төрийн байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал (төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал)
- Материаллаг зардал (төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал)
- Бусад зардал (тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал)-ыг тус тус тооцож гаргана.

3.1. Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтоодог.

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь нийт 30 албан хаагчтай чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд Төрийн тусгай албан хаагчийн ТТ-7 – ТТ-15 болон Төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮ-1 зэрэглэлээр цалинждаг¹⁰² байна.

Хүснэгт 7. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, цол, цалингийн зэрэглэл, орон тоо

Д/д	Албан тушаал	Цолны зэрэглэл	Цалингийн зэрэглэл	Орон тоо
1	Хэлтсийн дарга	Цагдаагийн хурандаа	ТТ – 15	1
2	Тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ – 13	2
3	Ахлах мэргэжилтэн	Цагдаагийн хошууч	ТТ – 12	1
4	Эрүүгийн ахлах мөрдөгч	Цагдаагийн хошууч	ТТ – 12	4
5	Эрүүгийн мөрдөгч	Цагдаагийн ахмад	ТТ – 11	12
6	Мэргэжилтэн	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
7	Мэдээлэл, холбоо, сүлжээний инженер	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
8	Сэтгэл зүйч	Цагдаагийн ахмад	ТТ – 10	2
9	Бичиг хэргийн эрхлэгч, архивч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	1
10	Цагдаа – жолооч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	3
11	Үйлчлэгч	Энгийн	ТҮ – 1	1

Дээр дурдсан албан хаагчдын цалингийн хэмжээг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”¹⁰³ 472 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг үндэслэн 1 хүний дундаж цалингийн үнэлгээг гаргав. Ингэхдээ тухайн ажил, үүргийг гүйцэтгэдэг буюу “хамгаалалтын арга хэмжээ” авахад хэрэгжүүлэх тус хэлтсийн Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн албан хаагчдын цалингийн хэмжээг авч үзлээ.

Хүснэгт 8. Албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Дундаж цалин
ТТ – 12	719990	770718	819842	865643	912829	817,804₮
ТТ – 11	692493	740806	787589	831210	876151	785,649₮

¹⁰² Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/136 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл”.

¹⁰³ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” <https://www.legalinfo.mn/law/details/14892>, (сүүлд үзсэн 2020.02.01).

ТТ - 10	666304	712316	756873	798418	841216	755,025₮
ТТ - 7	594989	634796	673225	709113	776260	677,676₮

Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 30%-иар¹⁰⁴ нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцож, нийтлэг болон дагалдах зардал болоод хүний нөөцийн нийт дундаж зардлыг дараагийн хүснэгтүүдээр тооцох болно. Ингэхдээ Хүснэгт 8-ын хүрээнд авсан цалингийн зэрэглэл тус бүрээр нэг албан хаагчид ногдох нэмэгдлийн мөнгөн дүнг тооцоолъё.

Хүснэгт 9. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

/ТТ – 12 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	817,804₮		817,804₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	817,804₮	30%	245,341₮
Нийт			1,063,145₮

Хүснэгт 10. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

/ТТ – 11 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	785,649₮		785,649₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	785,649₮	30%	235,694₮
Нийт			1,021,343₮

Хүснэгт 11. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

/ТТ – 10 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	755,025₮		755,025₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	755,025₮	30%	226,507₮
Нийт			981,532₮

Хүснэгт 12. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

/ТТ – 7 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	677,676₮		677,676₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	677,676₮	30%	203,302₮
Нийт			880,978₮

¹⁰⁴ Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2016 он, 286 дахь тал.

Хүснэгт 13. Хүний нөөцийн дундаж зардал /1 жилээр^{105/}

Цалингийн зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл /30%/	Хоол, унаа/өдөр	Хоол, унааны мөнгөн дүн	1 сарын цалин	12 сарын цалин	НДШ	Нийт /төгрөгөөр/
ТТ – 12	817,804	245,341	5000	110,000	1,063,145	12,757,740	1,403,351	14,161,091
ТТ – 11	785,649	235,694	5000	110,000	1,021,343	12,256,116	1,348,173	13,604,289
ТТ – 10	755,025	226,507	5000	110,000	981,532	11,778,384	1,295,622	13,074,006
ТТ – 7	677,676	203,302	5000	110,000	880,978	10,571,736	1,162,890	11,734,626
Нийт дундаж зардал								13,143,503₮

Ийнхүү дээрх хүснэгтүүдээс үзвэл нэг албан хаагчид зэрэглэлээсээ хамаарч тодорхой хэмжээний ялгаатай зардал үүсэж буй бөгөөд хүний нөөцийн зардлын дундаж нь 1 албан хаагч 1 жилд 13,143,503 /арван гурван сая нэг зуун дөчин гурван мянга таван зуун гурав/ төгрөг авах юм.

3.2. Материаллаг зардал

Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбоотой нийтлэг зардал буюу тухайн үүргийг гүйцэтгэж буй албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг хамааруулдаг. Тухайлбал, ажлын байр, эд хөрөнгө, техник хэрэгсэл, тэдгээрийн элэгдэл хорогдол, бусад ахуйн зардлыг тооцох шаардлагатай.

Тус зардлыг тооцохдоо “Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”¹⁰⁶-д үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны нэг ажилтанд зарцуулагдах материаллаг зардлыг¹⁰⁷ ашиглалаа.

¹⁰⁵ Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 286 дахь тал.

¹⁰⁶ Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2012 он, 97 дахь тал.

¹⁰⁷ Гэвч тэрхүү материаллаг зардлын мөнгөн дүн нь 2012 оны тоон мэдээлэл болох тул агуулгыг удирдлага болгон “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага”-ын дагуу үнийн дүнг авч тооцов. Тус хавсралтын зарим агуулгыг мөн хүснэгтэд нэмсэн болно. (Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 287 дахь талаас үзнэ үү.)

Хүснэгт 14. Нэг албан хаагчид гарах материаллаг зардал /1 жилээр/

Зардлын нэр		Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Хангамж, бараа материалын зардал	Бичиг хэрэг	640,000₮
		Ном, хэвлэл	1,625,000₮
		Шуудан холбоо	306,812₮
		Гэрэл, цахилгаан, сантехник, бусад эд хогшлын холбогдолтой сэлбэг хэрэгсэл, гэрлийн шил, залгуур зэрэг ¹⁰⁸	1,800,000₮
		Цэвэрлэгээний материал ¹⁰⁹	960,000₮
		Нийт	7,331,812₮
	Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал	Түлш, халаалт	263,408₮
		Гэрэл, цахилгаан	128,239₮
		Цэвэр, бохир ус	599,438₮
		Урсгал засвар	127,752₮
		Нийт	1,118,837₮
	Урсгал засвар	Компьютер, тоног төхөөрөмжийн засвар	456,000₮
		Автомашини засвар үйлчилгээ, тос масло ¹¹⁰	2,000,000₮
		Нийт	2,456,000₮
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Автотээврийн хэрэгслийн татвар	185,000₮
		Автотээврийн утааны татвар	3500₮
		Газрын төлбөр	22,253₮
		Нийт	210,753₮
	Элэгдэл, зардал ¹¹¹ хорогдлын	Техник, тоног төхөөрөмж ¹¹²	160,000₮
		Тавилга, эд хогшил ¹¹³	100,000₮
		Барилга, байгууламж ¹¹⁴	65,670₮
		Нийт	325,670₮

Эдгээр зардлууд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Хүснэгт 15. Ажлын байрны нийт дундаж материаллаг зардал /1 жилээр/

Ажлын байрны дундаж материаллаг зардал = 11,443,072₮

Хангамж, бараа материалын зардал /7,331,812₮/ + Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал /1,118,837₮/ + Урсгал засвар /2,456,000₮/ + Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210,753₮/ + Элэгдэл хорогдлын зардал /325,670₮/

Дээрхээс үзвэл нэг албан хаагчид гарах материаллаг зардал нь жилд 11,443,072 /арван нэгэн сая дөрвөн зуун дөчин гурван мянга далан хоёр/ төгрөг байна.

¹⁰⁸ Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс.

¹⁰⁹ Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгалд хамаарах бөгөөд хангамж, бараа материалын зардлын нэг хэсэг болдог байна.

¹¹⁰ Нэг ширхэг автомашинд ногдох зардал.

¹¹¹ МУЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”.

¹¹² Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Үнийг дунджаар 800,000₮ гэж тооцоход 20% нь элэгдэл, хорогдол буюу 160,000₮ болно.

¹¹³ Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Эд хогшил болох ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратын үнийг дунджаар 1,000,000₮ гэж тооцоход 10% нь элэгдэл хорогдол буюу 100,000₮ болно.

¹¹⁴ ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-т заасны дагуу нэг дэс түшмэлд ногдох ажлын өрөөний талбай 8м2 талбай байна. Үүнээс 2,300,000,000₮ 4483м2 = 513,049.29₮ нь 1м2 талбайн өртөг бөгөөд 8м2 талбайн өртөг нь 4,104,394.37₮ болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4,104,394.37₮ гэж тооцоход 1,6% нь элэгдэл хорогдол буюу 65,670₮ болно.

3.3. Бусад зардал

Бусад зардалд тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг авч үздэг. Төсөлтэй холбогдуулан дараах төрлийн бусад зардал гарахаар байна. Үүнд,

1. “Хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардагдах бусад зардлын хүрээнд нэг үйлчлүүлэгчид ногдох нэг удаагийн нийт зардлыг тооцох шаардлагатай бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”¹¹⁵-ыг баримжаалан шаардлагатай дүнг авч үзлээ.

Хүснэгт 16. Түр хамгаалах байранд байрлах нэг үйлчлүүлэгчид ногдох нэг хоногийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
1	Байр	2000₮
2	Хоол, цай	4000₮
3	Ариун цэвэр	600₮
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	2000₮
5	Нийгмийн ажлын үйлчилгээ	1000₮
6	Сэтгэл зүйн үйлчилгээ	2000₮
7	Аюулгүй байдлын үйлчилгээ	2000₮
10	Хууль зүйн зөвлөгөө	3000₮
11	Цэвэрлэгээ, үйлчилгээ ¹¹⁶	2,550
Нийт		19,150₮

Хүснэгт 17. Сургалтад хамрагдах нэг суралцагч (үйлчлүүлэгч)-д ногдох зардлын дээд хэмжээ

№	Зардлын төрөл	Ажлын 5 өдөр	Ажлын 10 өдөр
1	Бичиг хэрэг	2000₮	2000₮
2	Тараах материал, гарын авлага	2000₮	4000₮
3	Цайны зардал	3000₮	6000₮
4	Хоол, унааны мөнгө	8500₮	17,000₮
5	Дадлагын материал	3000₮	6000₮
Нийт		18,500₮	35,000₮

Хүснэгт 18. Бусад зардлын нийт хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ
Түр хамгаалах байр /90 хоног/ ¹¹⁷	1,723,500₮
Бичиг баримттай холбоотой үйлчилгээ /1 хүн/ ¹¹⁸	79,600₮

¹¹⁵ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралт, <http://hudulmur-halamj.gov.mn/uploads/document/5f826e04bbd963714254f01897cd357f2e6cb642.pdf> (сүүлд үзсэн 2020.02.01).

¹¹⁶ Мөн тэнд. Түр хамгаалах байрны 1 хоногийн зардалд “Цалин, шимтгэл” гэдгийг нэгтгэн “цэвэрлэгээ, үйлчилгээний хөлс” гэж өөрчилсөн ба нийт үнийн дүнд өөрчлөлт ороогүй болно. /ажилтны цалин хөлсийг хүний нөөцийн зардалд тооцсон тул энд давхардуулан тооцох шаардлагагүй гэж үзлээ./

¹¹⁷ “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартад зааснаар “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлэх газрыг хэлэх бөгөөд нийт зардлыг тооцохдоо дээд хугацаа болох 3 сар буюу 90 хоногийн хугацаагаар тооцов. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэг хоногийн зардлыг 90 хоногоор үржүүлэн нийт дүнг гаргасан.

¹¹⁸ А/80 дугаар тушаалын хавсралтад бичиг баримттай холбоотой үйлчилгээний зардлыг тусгаснаас нийт дүнг авав.

Сургалтад хамруулах /Ажлын 10 өдөр/	35,000₮
Эмчийн үзлэг, бариа засал, эм тариа ¹¹⁹	42,000₮
Нийт	1,880,100₮

Дээрхээс үзвэл “хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардагдах бусад зардал буюу нэг үйлчлүүлэгчид ногдох нэг удаагийн нийт зардлын дээд хэмжээ 1,880,100₮ /нэг сая найман зуун наян мянга нэг зуу/ гэж тооцлоо.

ДӨРӨВ. ЗАРДЛЫГ НЭГТГЭН ТООЦОХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд улсын төсвөөс гарах нийт зардлыг тооцож гаргах бөгөөд өмнөх үе шатанд тооцсон хүний нөөц, материаллаг зардал болон бусад зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлснээр нийт зардал гарна.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцож гаргахдаа тохиолдлын тоог хоёр төрлөөр тооцсон тул зардлыг нэгтгэн тооцоходоо мөн хоёр төрлөөр гаргах шаардлагатай юм.

а/ Хамгаалалтад авсан иргэдийн тоотой холбогдон гарах нийт зардал

Хүснэгт 17. Нийт зардал

(13,143,503₮ /хүний нөөцийн зардал/ + 11,443,072₮ /материаллаг зардал/ + 1,880,100₮ /бусад зардал/) х 0.27 /хүний нөөцийн хэрэгцээ/ = 7,146,002.25₮
--

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалах арга хэмжээ авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход 7,146,002.25₮ /долоон сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр төгрөг хорин таван мөнгө/-ийн зардал гарахаар байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын зохицуулалтын дагуу төр, хувийн салбарт ажиллагч, олон нийтийн төлөөлөл, гэрч, хохирогч, шинжээч нь шүгэлдэгч байж болох тухай заасан хэдий ч эдгээртэй холбоотой ирүүлсэн мэдээллийн нэгдсэн тоо бүртгэл Монгол Улсын хэмжээнд хийгдэггүй байна байна.

Гэрч, хохирогч нь шүгэл үлээгчийн зөвхөн нэг хэсэг байх тул дээрх тоог нэмэгдүүлэн тооцох үүднээс АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоогоор /Хүснэгт 18/ гарах зардлыг тооцож үзлээ.

б/ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол тоогоор тооцоолсон нийт зардал

Хүснэгт 18. Нийт зардал

(13,143,503₮ /хүний нөөцийн зардал/ + 11,443,072₮ /материаллаг зардал/ + 1,880,100₮ /бусад зардал/) х 2.8 /хүний нөөцийн хэрэгцээ/ = 74,106,690₮

Хүснэгтээс үзвэл АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 74,106,690₮ /далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ерэн төгрөг/-ийн зардал гарах юм.

4.1. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Энэ үе шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар, боломж байгаа эсэхийг шалгадаг. Ингэхдээ дараах хувилбар, боломжуудыг дэвшүүлэн шалгаж үзье. Үүнд:

- Төсвийн зардлыг багасгах боломж байгаа эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх;

¹¹⁹ Мөн тэнд. Нэг үйлчлүүлэгчид шаардлагатай уламжлалт болон орчин үеийн аргаар сэргээн засах үйлчилгээний дүнг нэгтгэн гаргасан.

- Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх зэрэг болно.

Төсвийн зардлыг багасгах боломж, зохицуулалтын өөр хувилбар бий эсэх:

Дээрхээс үзвэл хамгаалалтад авах шаардлагатай иргэдийн тооноос хамааруулан төсөвт үүсэх зардлыг тодорхой хэмжээгээр багасгаж болох хэдий ч төсвийн зардлыг бууруулах шалтгаан, зохицуулалтын өөр хувилбар эрэлхийлэх нь төдийлөн оновчтой биш байна.

Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх:

Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоо уг судалгаанд туссан мэдээлсэн иргэдийн тоотой харьцуулан үзвэл бага байх тул шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр эдийн засгийн хувьд үр ашигтай байх зарчмыг баримтлах, боломжтой арга замыг эрэлхийлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн багт даатгах, аюулгүй байдлын хамгаалалтыг мөн адил, нэг цэгийн үйлчилгээ, бусад хамгаалах байруудын үйлчилгээтэй нэгтгэн зохицуулах, анхан шатны тусламж үйлчилгээг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж болох юм.

4.2. Үр дүн

Төсөлд шинээр тусгагдсан “шүгэл үлээгчийг хамгаалах” болон “мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох”-д төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолов. Ингэхдээ тохиолдлын тоо болон мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнг дараах янзаар авч үзэн тусад нь тооцсон болно.

Тийнхүү тусад нь авч үзсэний үндсэн дээр гарсан тооцоог нэгдсэн байдлаар дурдвал:

а/ Хамгаалалтад авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход 7,146,002.25₮ /долоон сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр төгрөг хорин таван мөнгө/-ийн зардал, 0.27 хүний нөөцийн хэрэгцээ;

б/ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 74,106,690₮ /далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ер/ төгрөгийн зардал, 2.8 хүний нөөцийн хэрэгцээ тус тус үүсэж байна.

Дээрхээс үзэхэд ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалалтын арга хэмжээ авсан иргэдийн тоогоор зардлыг тооцоолох нь улсын төсөвт үүсэх зардал, ачаалал харьцангуй бага байна. Харин АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон зардлыг тооцож тэдгээрийн дунджийг тооцоолсноор “хамгаалалтын арга хэмжээ”-г авах төрийн байгууллагад буюу улсын төсөвт жилд дунджаар 74,106,690₮ /далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ер / төгрөгийн зардал, 2.8 хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

ТАВ. Дүгнэлт

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг.

Шүгэл үлээснээр иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн, зардал ачаалал үүсэх зохицуулалтгүй байна. Нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох үүргийг байгууллагад хүлээлгэсэн байгааг хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэг хэмээн үзэж

болохгүй юм. Учир нь “зөрчил гарсан тохиолдолд” хийгдэх үйл ажиллагааг тооцон гаргах нь огт хийгдэхгүй ч байж болох юм. Иймд, төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийн дагуу үүсэх зардал, ачааллыг урьдчилсан байдлаар тооцов. Ингэхдээ зардал үүсгэх боломжтой зүйл, заалт буюу төслийн Гуравдугаар бүлгийн “Шүгэл үлээгчийг хамгаалах”-тай холбогдуулан гарах зардлын тооцоог хийлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан үйл ажиллагааг төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааг нэг бүрчлэн тооцоход шаардлагатай төрийн байгууллагаас авч болох тоон мэдээлэл хомс байх тул төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын дагуу “хамгаалалтын арга хэмжээ” авч хэрэгжүүлэх заалт, холбогдох хуулиар заасантай уялдуулан ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалалтад авсан иргэдийн тоог үндэслэсэн. Мөн нэг байгууллагын зардлаар улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг гаргах боломжгүй гэж үзэн АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоог авч тэдгээрийн дунджийг тооцоолсноор шүгэл үлээгчид туслалцаа үзүүлэхэд шаардлагатай нийт мөнгөн дүнг тооцоолон гаргасан.

АТГ-т “мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох” талаар шууд үүрэг болгон, төсөвт төвлөрөх орлого, түүнээс олгох мөнгөн шагналын хэмжээг заасан хэдий ч хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай уялдаа холбоогүй, ойлгомжгүй, хийдэлтэй байгаа нь зардлыг бодитоор урьдчилан тооцоход хүндрэлтэй нөхцөлийг үүсгэж байх тул аргачлалын дагуу стандарт үйл ажиллагаа хийгдэх боломжгүй юм.

Төслийг хэрэгжүүлснээр улсын төсөвт тодорхой хэмжээний ачаалал үүсгэх хэдий ч гэрч, хохирогч болон шүгэл үлээгчийг хамгаалах үйл ажиллагаа нь багагүй зардлыг шаарддаг. Шаардлагатай туслалцааг зүй ёсоор үзүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийг баталгаатай эдлүүлэх, НАСТШҮХТХ-н зорилтыг хангахад чиглэсэн чухал алхам юм. Энэхүү зардлын мөнгөн дүнг эргээд ямар замаар эргэн төвлөрүүлэх, төсөвт ашигтай байдлаар зохицуулах тухай асуудал бодитоор урган гарна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Төслийн “Шүгэл үлээгчийг хамгаалах” хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зүйл заалтын тухайд 16 дугаар зүйлийн 16.2, 16.4, 16.5 дахь заалтын “...арга хэмжээ авч болно.” гэснийг “...арга хэмжээ авна.” гэж, 16.6 дахь заалтын “...хамгаалалтын арга хэмжээнд хамруулж болно.” гэснийг “...хамгаалах шийдвэр гаргуулж болно.” гэж тодорхой заан өөрчлөн найруулах,
- НАСТШҮХТХ, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хуулийн уялдаа холбоог нягтлах, нарийвчилсан зохицуулалт бий болгох буюу “хамгаалалтын арга хэмжээ” авахад зарцуулагдсан зардлыг эргээд хэрхэн төвлөрүүлэх талаар арга зам, боломжит хувилбарыг эрэлхийлэх;
- Төрийн байгууллагад орох орлогыг уг хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан “... захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан олж авсан...” гэж зааснаар хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Учир нь 1/ нийтийн ашиг сонирхлыг “захиргааны байгууллагад” гэж хязгаарласан, 2/ “учирсан хохирлыг” гэж өнгөрсөн цагт авч үзсэн нь хуулийн зорилтод тодорхойлсон үндсэн үзэл санааг хэрэгжүүлэхэд саад болох төдийгүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “олон нийтийн итгэл” гэснийг авч үзэх, хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “...хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн” гэсэн заалттай зөрчилдөж байх тул нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл үүссэн гэсэн 2 үндэслэлийг авч үзэж

орлогыг тооцох нь зүйтэй байна. Энэ мэт хууль хоорондын болон хуулийн төслийн зүйл заалт хоорондын уялдаа холбоог хангах нь шүгэл үлээгчийг дэмжсэн хууль бус үйлдэлтэй тэмцсэнээр уг хуулийн төслийн үзэл санаа бүрэн утгаар хэрэгжих төдийгүй төрийн байгууллагад орлого бүрдэх боломжтой болох юм.

- Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг авах тухай хүсэлт гаргаж болох тухай заасан хэдий ч хэн, хэзээ, хэрхэн олгох талаар уг хуулийн төсөлд тусгаагүй байгаа нь хуулийн хийдэл үүсгэж зардал тооцох боломжгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 2003 он.
- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №1
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 он, №35
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 он, №1
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №30

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”
- Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”
- Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай /дугаар 21/
- Хуулийн төслийг буцаах тухай /дугаар 20/
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013 оны /дугаар 20/

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт
- “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоол
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоол
- Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- Хохирогчид нөхөх олговор олгох журам батлах тухай, Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн дугаар 294 тогтоол
- Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар 115 /Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай/
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол

САЙДЫН ТУШААЛ

- Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар А/91 тушаал, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам
- Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн дугаар А/135 дугаар тушаал, Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад

хамруулах үйлчилгээ үзүүлэх журам

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 дугаар тушаал, Биечилсэн хамгаалалтын журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.3/
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.4/
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/113 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.5/
- Хууль зүй, дотоод хэргийн сайд сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/114 дүгээр тушаал, Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.6/
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн дугаар А/84, /А/59/, А/130 дугаар тушаал, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/250, А-171 дугаар тушаал, Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.3/
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаал, Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/394 дүгээр тушаал, Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/80, А/132, А/60, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэх журам

НОМ, ГАРЫН АВЛАГА

- Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. 2019 он.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо. 2018 он.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. 2018 он.
- Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018)
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2016

Нийтийн ашиг сонирхолын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн хүрээнд хүлээлгэсэн үүрэг

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зохицуулалт
1.	5 дугаар зүйл. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг	5.1.Байгууллага нь нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг /цаашид "шүгэл үлээгч" гэх/ дэмжих, хамгаалах үүрэгтэй. 5.2.Захиргааны байгууллага нь хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс нийтийн ашиг сонирхлыг хохирохоос урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж болно. 5.3.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч нь ажил мэргэжлээ солих, албан тушаалаа өөрчлөх, түр хугацаагаар өөр үүрэг гүйцэтгэх зэрэг хүний нөөц, ажлын байртай холбоотой арга хэмжээ авах үндэслэл бүхий хүсэлт гаргавал тэрхүү хүсэлтийг тухайн байгууллагын удирдлага даруй шийдвэрлэнэ. 5.4.Байгууллага нь энэ хуулийн зохицуулалтад нийцүүлэн нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам гаргаж мөрдөнө.
2.	6 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ	6.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараахь асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана: 6.1.1.нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах; 6.1.2.мэргэжлийн хяналт шалгалт явуулах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагатай харилцан хамтран ажиллах; 6.1.3.шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах; 6.1.4.шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх; 6.1.5.олон нийтэд шүгэл үлээгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжихтэй холбоотой сургалт, сурталчилгаа явуулах; 6.1.6.шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; 6.1.7.хуульд заасан бусад.
3.	7 дугаар зүйл. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	7.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж илчилсэн мэдээллийг хүлээн авсан болон түүний мөрөөр хянан шалгасан, шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авсан, цуцалсан, хохирол арилгасан, шагнал, урамшуулал олгосон зэрэг шүгэл үлээсэнтэй холбогдуулан авсан арга хэмжээний талаар тусгасан мэдээллийн нэгдсэн сан бий болгож ажиллана. 7.2.Мэдээллийн нэгдсэн санд тусгах шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага Авлигатай тэмцэх газраас албан бичгээр тавьсан хүсэлтийг хүлээж авснаас хойш долоо хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй. 7.3.Авилгатай тэмцэх газар нь мэдээллийн нэгдсэн санд тусгасан мэдээллийг энэ хуулийн зорилгод нийцүүлэн хадгалах ашиглах, хамгаалах арга хэмжээ авна. 7.4.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах тухай журмыг Авилгатай тэмцэх газрын дарга батална. 7.5.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн талаар статистик мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан нийтэд мэдээлж байх ба дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлж байна.

4.	14 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид зөвлөгөө өгөх	14.2.Шүгэл үлээгч энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт гаргах ба тухайн байгууллага зөвлөгөө өгөх ажлыг хүсэлтийг хүлээн авснаас хойш даруй зохион байгуулна.												
5.	16 дугаар зүйл.Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах	16.4.Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно. 16.5.Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно												
6.	19 дүгээр зүйл.Шүгэл үлээгчийг дарамт, шахалтаас хамгаалах	19.7.Энэ хуулийн 18.1-д заасан дарамт шахалт шүгэл үлээгчид үзүүлснээс хойш тухайн этгээд дахин ийм арга хэмжээ авсан эсэх дээр Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ.												
7.	20 дугаар зүйл.Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох	20.2.Энэ хуулийн 20.1-д зааснаар мөнгөн шагнал авах өргөдөл ирүүлснээс хойш долоо хоногийн дотор Авлигатай тэмцэх газраас Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулах ба уг зөвлөлөөс хэлэлцэн шийдвэрлэсний дагуу дараахь хэмжээг баримтлан мөнгөн шагнал олгоно: <table><tr><td>Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/</td><td>Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/</td></tr><tr><td>50 сая хүртэл</td><td>20 хувь</td></tr><tr><td>50 саяас 250 сая</td><td>10 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ</td></tr><tr><td>250 саяас 1 тэрбум</td><td>36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ</td></tr><tr><td>1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум</td><td>113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ</td></tr><tr><td>2 тэрбумаас дээш</td><td>173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ</td></tr></table> 20.3.Мөнгөн шагнал нь 100 мянган төгрөгөөс 1 тэрбум 500 сая төгрөг хүртэл байна. 20.4.Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэгтэй холбоотойгоор мэдээлэл өгч шүгэл үлээсэн тохиолдолд энэ хуулийн 20.2-т заасан мөнгөн шагналын 50 хувийг олгоно. 20.6.Авлигатай тэмцэх газар мөнгөн шагнал олгох эсэх асуудлыг шүгэл үлээгчийн өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж, шүгэл үлээгчид албан бичгээр мэдэгдэнэ. 20.7.Авлигатай тэмцэх газар мөнгөн шагнал олгох эсэхтэй холбоотой хяналт шалгалт явуулах бол энэ хуулийн 20.6-д заасан хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно. 20.8.Энэ хуулийн 20.7-д заасан хяналт шалгалт явуулах нөхцөлд шаардлагатай материал, тайлбар ирүүлэхийг мөнгөн шагнал хүссэн өргөдөл гаргагч, лавлагаа, тодорхойлолт гаргах этгээд, холбогдох байгууллагаас хүсч болно. Мөнгөн шагнал хүссэн өргөдөл гаргагч, лавлагаа, тодорхойлолт гаргах этгээд, холбогдох байгууллага энэхүү хүсэлтийг хангах үүрэгтэй.	Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/	Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/	50 сая хүртэл	20 хувь	50 саяас 250 сая	10 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ	250 саяас 1 тэрбум	36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ	1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум	113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ	2 тэрбумаас дээш	173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ
Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/	Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/													
50 сая хүртэл	20 хувь													
50 саяас 250 сая	10 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ													
250 саяас 1 тэрбум	36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ													
1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум	113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ													
2 тэрбумаас дээш	173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ													

8.	21 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид урамшуулал олгох	21.1.Авлигатай тэмцэх газар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээснээр захиргааны байгууллагад учрах байсан бодит хохирлоос сэргийлсэн болон доор дурдсан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг дэмжсэн бол урамшуулал олгох талаар Мөнгөн шагнал олгох зөвлөлөөр хэлэлцүүлж энэ тухай зөвлөмж гаргана: 21.1.1.нийтийн ашиг сонирхлыг хохироосон этгээдэд шийтгэл, ял, албадлагын арга хэмжээ оногдуулсан; 21.1.2.залруулах арга хэмжээ авах, хориглох зэрэг тусгай үйлдэл шаардлагатай захиргааны арга хэмжээ авсан; 21.1.3.нийтийн ашиг сонирхлыг хохироох үйлдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн журам, дүрэм, хууль тогтоомж батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг тогтолцоог сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан. 21.2.Урамшуулал олгох тухай зөвлөмжийг гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ хуулийн 21.4-т заасан байгууллагад хүргүүлэх ба шүгэл үлээгчид мэдэгдэнэ. 21.3.Энэ хуулийн 21.1-д заасан урамшууллын хэмжээ 500 000 төгрөг байх ба мөнгөн шагналтай давхардуулан олгохгүй. 21.4.Урамшууллыг энэ хуулийн 5.1-д заасан үүргийн дагуу шүгэл үлээгчийн ажиллаж байгаа байгууллагаас олгоно. 21.5.Энэ хуулийн 21.1-д заасан үндэслэл бий болсон байхад урамшуулал олгоогүй бол шүгэл үлээгч Авлигатай тэмцэх газарт болон шүүхэд гомдол гаргаж болно.
9.	22 дугаар зүйл.Шүгэл үлээгчид нөхөн төлбөр олгох	22.1.Шүгэл үлээгч, түүний хамаарал бүхий этгээдэд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авахад гарах зардал нь тухайн хуульд заасны дагуу зохицуулагдана. 22.2.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдэд хамгаалалтын арга хэмжээ авснаас гадна болон хамгаалалтын арга хэмжээ аваагүй байхад учирсан хохиролтой холбогдуулан нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргаж болно.
10.	23 дугаар зүйл.Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох	23.1.Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан мөнгөн шагнал, 21 дүгээр зүйлд заасан урамшуулал авах этгээд адил үндэслэлээр бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно. 23.2.Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй 23.3.Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.
11.	24 дүгээр зүйл.Мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг буцаан авах	24.1.Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага дараахь тохиолдолд мөнгөн шагнал, урамшуулал авсан шүгэл үлээгчид мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш гурван сарын дотор шүгэл үлээгч нь урьд авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг буцааж өгнө: 24.1.1.мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг хуурамч баримт бичиг бүрдүүлж, эсхүл үндэслэлгүйгээр олж авсан тохиолдол; 24.1.2.энэ хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасныг зөрчиж мөнгөн шагнал, урамшуулал олгосон; 24.1.3.мөнгөн шагналын мөнгийг буруу тооцож олгосон. 24.2.Шүгэл үлээгч энэ зүйлийн 24.1-д заасны дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг заасан хугацаанд буцааж өгөөгүй тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллагаас шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх замаар төсөвт төвлөрүүлэх орлого

Төслийн 6 дугаар зүйлийн 1.4-д “Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх” хэмээн АТГ-т үүрэг болгосон хэдий ч шаардлагатай төрийн байгууллагаас авч болох тоо мэдээлэл хомс, энэ талаарх мэдээллийг тусгайлан бүртгэдэггүй, мэдээлэл төвлөрсөн газар байхгүй зэрэг шалтгаанаас үүдэн нарийвчилсан тоо гаргахад хүндрэлтэй хэдий ч 2015-2018 оны Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг баримжаалан авч үзлээ. Нийтийн ашиг сонирхыг төлөө шүгэл үлээснээр төсвийн орлогыг нэг бүрчлэн тооцох нь төрд илүү ашигтай. Учир нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь дийлэнх тохиолдолд төр байдаг бөгөөд учирсан хохирлыг нь төрийн олох ёстой байсан орлого хэмээн үзэх боломжтой юм.

	2015	2016	2017	2018	дундаж
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	50,300,000,000	37,727,800,000	69,546,211,566	663,213,994,905	205,197,001,617
Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн	2,900,000,000	2,808,900,000	3,412,008,000	17,470,753,530	6,647,915,382

Дээрх хүснэгтээс үзвэл Авлигын гэмт хэргээс жилд дунджаар 205,197,001,617 төгрөгийн хохирол учирдаг бөгөөд үүнээс жилд дунджаар 3.2% буюу 6,647,915,382 төгрөгийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлдэг байна.

Төслийн 20.2 дахь хэсэг. Мөнгөн шагналын хувь хэмжээ

Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/	Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/
50 сая хүртэл	20 хувь
50 саяас 250 сая	10 төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ
250 саяас 1 тэрбум	36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ.
1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум	113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ
2 тэрбумаас дээш	173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ

Хуулийн төсөлд тусгагдсаны дагуу авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол буюу төсөвт төвлөрүүлэх орлогын сүүлийн 4-н жилийн дундаж үзүүлэлтээр тооцсон мөнгөн шагналын хэмжээ нь $173,000,000 + (203,197,001,617 \div 4) = 8,300,880,064.68$ төгрөг байна. Гэсэн хэдий ч энэхүү хэмжээ нь төрд 205,197,001,617 төгрөгийн хохирлыг буруутай этгээдээдээс нөхөн төлсний дараа үүсэх зардал юм. Иймд төслийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтаас 20.1.4-д заасны дагуу мөнгөн шагналыг Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн төгрөгөөс тооцон үзвэл $173,000,000 + (4,647,915,382 \div 4) = 358,916,615.28$ төгрөгний мөнгөн шагнал олгохоор байна.

Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох нь тодорхой үр дагавар үүсэх буюу төсөвд орлого оруулсны үндсэн дээр гарах зардал байх тул мөнгөн шагналыг Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн зардлыг

баримжаалан тооцоход 358,916,615.28 төгрөгний зардал урамшууллыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тооны дунджаар баримжаалан авч үзэхэд 296,500,000 төгрөг буюу нийт 655,416,615 төгрөгний зардал гарахаар байна.

Харин төслийн 21 дүгээр зүйлийн 1-д зааснаар урамшуулал олгох үндэслэлийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээснээр захиргааны байгууллагад учрах байсан бодит хохирлоос сэргийлсэн болон доор дурдсан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг дэмжсэн бол хэмээн тодорхойлон урамшууллын хэмжээг 500,000 төгрөг байхаар тогтоосон байна. Дээрх зардлыг тооцоход дээр дурдсанчлан нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл байхгүйгээс бодит тоог гаргахад хүндрэлтэй байгаа тул Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст ирүүлсэн гомдол мэдээллийн тоог баримжаалан зардлыг тооцлоо. Хүснэгт 3-аас харахад жилд дунджаар 593-н мэдээлэл ирдэг бөгөөд үүнд урамшуулал олгосон тохиолдолд 296,500,000 (593 Ч 500,000) төгрөгний урамшуулал олгогдохоор байна.

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn